



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШШГЕГ-ЫН ХАРЬАА 401-Р ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-НЭГДСЭН
ЭМНЭЛЭГ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/341/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2.1 Албан шаардлага	16
4.2.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/375
танай _____-ны № _____-т

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА 401 ДҮГЭЭР
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Д.ОДСЭР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллагын ашиглах зориулалттай, санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгөнд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд байршилтай Зайсангийн аман дахь 5.2 га газраас ашиглагч байгууллагад шилжүүлээгүй нь оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	259,515,330.48	369,770,949.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	423,531.68	5,291,013.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	423,531.68	5,291,013.28
3121	Төгрөг	423,531.68	5,291,013.28
31211	Төрийн сангийн харилцах	423,531.68	5,291,013.28
33	АВЛАГА	4,138,363.00	29,684,175.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	153,688.00	-
335	Бусад авлага	3,984,675.00	29,684,175.00
3351	Байгууллагаас авах авлага	520,675.00	26,220,175.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,464,000.00	3,464,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	254,953,435.80	334,795,761.33
351	Түүхий эд материал	146,663,483.36	190,059,653.07
35110	Тусгай зориулалттай материал	64,153,004.50	67,719,789.50
35130	Эм боох материал	82,510,478.86	122,339,863.57
354	Хангамжийн материал	89,817,952.44	124,674,108.26
35410	Бичиг хэргийн материал	7,744,490.00	2,454,120.00
35420	Аж ахуйн материал	52,527,556.40	80,551,966.72
35430	Сэлбэг хэрэгсэл	1,025,950.00	2,220,950.00
35440	Түлш, шатах тослох материал	4,038,700.00	3,237,000.00
35450	Барилгын засварын материал	26,404.00	19,964.00
35460	Хүнсний материал	15,965,703.50	12,451,787.00
35470	Бусад хангамжийн материал	8,489,148.54	23,738,320.54
35600	Мал амьтад	18,472,000.00	20,062,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,309,109,676.03	7,301,002,589.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,309,109,676.03	7,301,002,589.30
392	Биет хөрөнгө	5,489,541,470.88	5,481,862,589.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,834,014,671.02	5,834,014,671.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(891,116,944.60)	(999,771,360.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	243,571,000.00	243,571,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(193,854,925.32)	(205,973,655.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,371,284,760.75	1,598,888,387.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(972,850,392.23)	(1,066,585,710.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	260,421,744.07	249,605,544.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(182,451,605.31)	(190,285,698.75)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	18,554,100.00	18,554,100.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,430,000.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,497,500.00	21,497,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,528,437.50)	(20,222,187.50)
393	Биет бус хөрөнгө	1,819,568,205.15	1,819,140,000.11
39301	Программ хангамж	8,567,692.31	8,567,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,139,487.16)	(8,567,692.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,819,140,000.00	1,819,140,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,568,625,006.51	7,670,773,538.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,394,206.68	3,426,676.58
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,394,206.68	3,426,676.58
413	Өглөг	1,394,206.68	3,426,676.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,047,599.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	450,000.00	-
4136	Бусад өглөг	944,206.68	379,076.68
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	944,206.68	379,076.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,567,230,799.83	7,667,346,862.33

51	Засгийн газрын хувь оролцоо	7,567,230,799.83	7,667,346,862.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,469,705,487.64	2,469,705,487.64
51101	Өмч: - төрийн	2,469,705,487.64	2,469,705,487.64
512	Хуримтлагдсан үр дүн	5,097,525,312.19	5,197,413,374.69
51210	Өмнөх үеийн үр дүн	5,097,525,312.19	5,097,525,312.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	100,116,062.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,568,625,006.51</u>	<u>7,670,773,538.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,516,552,439.30	2,956,747,197.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123,544,239.30	362,606,806.50
120	Нийтлэг татварын бус орлого	123,544,239.30	247,001,516.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,544,239.30	229,494,904.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,250,655.94	12,384,866.67
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	108,293,583.36	217,110,038.23
120009	Бусад орлого	-	17,506,611.60
122	Тусламжийн орлого	-	115,605,290.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	115,605,290.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,393,008,200.00	2,594,140,391.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,509,691,600.00	1,452,663,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,509,691,600.00	1,452,663,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	258,098,791.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		258,098,791.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	883,316,600.00	883,378,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,378,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,690,947,845.36	2,830,413,635.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,690,947,845.36	2,830,413,635.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,683,525,445.36	2,790,673,834.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,622,581,100.00	1,616,281,205.20
210101	Үндсэн цалин	1,104,091,000.00	1,072,575,600.00
210102	Нэмэгдэл	499,607,100.00	519,946,090.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,883,000.00	15,120,000.00
210104	Урамшуулал	4,000,000.00	2,880,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	5,759,514.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,977,420.00	42,032,600.00
210201	Тэтгэврийн даатгал	9,451,570.78	
210202	Тэтгэмжийн даатгал	1,111,949.49	
210203	ҮОМШӨ-ний даатгал	889,559.71	
210204	Ажилгүйдлийн даатгал	158,495.37	
210205	Эрүүл мэндийн даатгал	31,365,844.65	42,032,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,316,700.00	129,901,273.46
210301	Гэрэл, цахилгаан	58,586,792.97	60,437,010.83
210302	Түлш, халаалт	31,931,064.92	32,273,429.63
210303	Цэвэр, бохир ус	27,798,842.11	37,190,833.00

2104	Хангамж, бараа материалын зардал	92,866,683.82	100,061,432.60
210401	Бичиг хэрэг	7,462,890.00	23,544,658.00
210402	Тээвэр, шатахуун	35,715,600.00	38,698,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,382,400.00	4,841,670.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,440,000.00	4,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,254,495.24	24,478,604.60
210408	Бараа материал акалсны зардал	9,611,298.58	4,147,800.00
2105	Норматив зардал	458,109,909.10	469,265,131.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	278,297,956.19	321,880,550.59
210502	Хоол, хүнс	173,825,688.35	142,842,456.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,986,264.56	4,542,124.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,545,580.00	51,512,720.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,327,100.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,044,050.00	3,218,540.00
210604	Урсгал засвар	30,174,430.00	48,294,180.00
2107	Томилолт, зочны зардал	780,000.00	480,000.00
210702	Дотоод албан томилолт	780,000.00	480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,902,785.00	103,304,365.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,154,530.00	20,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	714,055.00	942,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	224,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,038,200.00	20,198,200.00
210807	Газрын төлбөр	820,000.00	53,439,265.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	301,445,267.44	277,835,107.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,725,428.00	1,255,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,900.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	296,094,939.44	276,580,107.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,422,400.00	39,739,800.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,872,400.00	2,016,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,872,400.00	2,016,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,050,000.00	26,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	26,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,500,000.00	5,333,800.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,500,000.00	5,333,800.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,890,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,890,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(174,395,406.06)	126,335,562.50
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,765,400.00	26,217,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	32,765,400.00	26,217,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(32,765,400.00)	(26,217,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(207,160,806.06)	100,116,062.50

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,469,705,487.64	-	5,304,686,118.25	7,774,391,605.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,469,705,487.64	-	5,304,686,118.25	7,774,391,605.89
Тайлант үеийн үр дүн			(207,160,806.06)	(207,160,806.06)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,469,705,487.64	-	5,097,525,312.19	7,567,230,799.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,469,705,487.64	-	5,097,525,312.19	7,567,230,799.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-			
Тайлант үеийн үр дүн			100,116,062.50	100,116,062.50
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,469,705,487.64		5,197,778,110.75	7,667,346,862.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,423,099,150.00</u>	<u>2,599,004,579.27</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,090,950.00	30,783,688.27
120	Нийтлэг татварын бус орлого	30,090,950.00	30,783,688.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,090,950.00	13,277,076.67
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,090,950.00	13,277,076.67
120009	Бусад орлого	-	17,506,611.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,393,008,200.00	2,568,220,891.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,509,691,600.00	1,452,663,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,509,691,600.00	1,452,663,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	232,179,291.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		232,179,291.00
131106	Төсвийн урамшуулал		
340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	883,316,600.00	883,378,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,378,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,418,051,900.00</u>	<u>2,517,367,397.67</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,418,051,900.00</u>	<u>2,517,367,397.67</u>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,410,629,500.00	2,477,533,757.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,622,581,100.00	1,633,280,891.00
210101	Үндсэн цалин	1,104,091,000.00	1,072,575,600.00
210102	Нэмэгдэл	499,607,100.00	519,778,491.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,883,000.00	15,120,000.00
210104	Урамшуулал	4,000,000.00	2,880,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	22,926,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,977,420.00	39,152,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,977,420.00	39,152,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,316,700.00	130,685,273.46
210301	Гэрэл, цахилгаан	58,586,792.97	60,437,010.83
210302	Түлш, халаалт	31,931,064.92	32,273,429.63
210303	Цэвэр, бохир ус	27,798,842.11	37,974,833.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,911,200.00	108,253,863.00
210401	Бичиг хэрэг	5,300,300.00	15,552,830.00
210402	Тээвэр, шатахуун	38,748,100.00	36,748,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,102,400.00	4,841,670.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,595,000.00	4,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,165,400.00	46,761,363.00
2105	Норматив зардал	488,349,500.00	401,847,865.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	336,609,000.00	272,916,765.00
210502	Хоол, хүнс	151,740,500.00	128,931,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,787,080.00	46,229,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,789,100.00	704,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,237,500.00	3,237,500.00
210604	Урсгал засвар	30,760,480.00	42,288,300.00
2107	Томилолт, зочны зардал	780,000.00	480,000.00
210702	Дотоод албан томилолт	780,000.00	480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,797,500.00	103,304,365.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,492,400.00	20,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	942,900.00	942,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	224,000.00	224,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,318,200.00	20,198,200.00
210807	Газрын төлбөр	820,000.00	53,439,265.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,129,000.00	14,299,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,504,100.00	14,299,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,422,400.00	39,833,640.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,872,400.00	2,016,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,872,400.00	2,016,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,050,000.00	26,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	26,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,500,000.00	5,333,800.21
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,500,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,333,800.21
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,983,840.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,983,840.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,047,250.00</u>	<u>81,637,181.60</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,247,000.00	76,769,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,247,000.00	76,769,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,247,000.00	76,769,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,247,000.00	76,769,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,247,000.00)	(76,769,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,199,750.00)	4,867,481.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,623,281.68	423,531.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	423,531.68	5,291,013.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,348,233,800.00	2,343,046,766.46	5,187,033.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,348,233,800.00	2,343,046,766.46	5,187,033.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,334,305,400.00	2,329,134,766.46	5,170,633.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,609,627,000.00	1,604,459,091.00	5,167,909.00
210101	Үндсэн цалин	1,072,575,600.00	1,072,575,600.00	-
210102	Нэмэгдэл	493,244,600.00	490,956,691.00	2,287,909.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,120,000.00	15,120,000.00	-
210104	Урамшуулал	5,760,000.00	2,880,000.00	2,880,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,926,800.00	22,926,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,732,000.00	38,732,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	38,732,000.00	38,732,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,936,700.00	116,934,375.46	2,324.54
210301	Гэрэл, цахилгаан	53,827,608.37	53,825,283.83	2,324.54
210302	Түлш, халаалт	30,134,258.63	30,134,258.63	-
210303	Цэвэр, бохир ус	32,974,833.00	32,974,833.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	65,857,900.00	65,857,900.00	-
210401	Бичиг хэрэг	7,552,830.00	7,552,830.00	-
210402	Тээвэр, шатахуун	36,748,000.00	36,748,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,841,670.00	4,841,670.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,350,000.00	4,350,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,365,400.00	12,365,400.00	-
2105	Нормативт зардал	366,581,100.00	366,581,100.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,106,000.00	244,106,000.00	-
210502	Хоол, хүнс	122,475,100.00	122,475,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,407,500.00	35,407,500.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,170,000.00	12,170,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,237,500.00	3,237,500.00	-
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	480,000.00	480,000.00	-
210702	Дотоод албан томилолт	480,000.00	480,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,383,700.00	95,383,700.00	

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,500,000.00	15,500,000	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	942,900.00	942,900.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	224,000.00	224,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,198,200.00	20,198,200.00	-
210807	Газрын төлбөр	51,518,600.00	51,518,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,299,100.00	4,299,100.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,299,100.00	4,299,100.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,928,800.00	13,912,000.00	16,800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,032,800.00	2,016,000.00	16,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,032,800.00	2,016,000.00	16,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,896,000.00	11,896,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,896,000.00	11,896,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,348,233,800.00	2,343,116,433.13	5,117,366.87
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,452,663,500.00	1,447,414,966.46	5,248,533.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,452,663,500.00	1,447,414,966.46	5,248,533.54
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	883,316,600.00	883,378,100.00	(61,500.00)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,378,100.00	(61,500.00)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,253,700.00	12,323,366.67	(69,666.67)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,253,700.00	12,323,366.67	(69,666.67)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	423,531.68	423,531.68	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,291,013.28	5,291,013.28	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	120	120	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	119	119	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		232,179,291.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		232,179,291.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		225,168,691.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		28,821,800.00
210102	Нэмэгдэл		28,821,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		420,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		420,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		13,750,898.00
210301	Гэрэл, цахилгаан		6,611,727.00
210302	Түлш, халаалт		2,139,171.00
210303	Цэвэр, бохир ус		5,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		42,395,963.00
210401	Бичиг хэрэг		8,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		34,395,963.00
2105	Нормативт зардал		39,006,765.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		35,006,765.00
210502	Хоол, хүнс		4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		83,852,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		56,852,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		27,000,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,920,665.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,000,000.00
210807	Газрын төлбөр		1,920,665.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7,010,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,310,000.00
2133	Ологосн санхүүжилт		4,700,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		232,179,291.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		232,179,291.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Биет бус хөрөнгө газартай холбоотой 2 албан шаардлага 2 зөвлөмж, бараа материал болон зардалтай холбоотой, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден Пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, шинжээч Б.Ариунтуяа, Б.Дэжидмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл, чанарын хяналтын менежер Б.Дашням нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйл ажиллагаа явуулдаг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,690,947.8 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 53,819.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,229.0 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал 79,842.4 мянган төгрөгөөр өссөн, үндсэн хөрөнгө 8,107.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	423.5	5,291.0	4,867.5
Авлага	4,138.4	29,684.2	25,545.8
Бараа материал	254,953.4	334,795.8	79,842.3
Үндсэн хөрөнгө	7,309,109.7	7,301,002.5	(8,107.1)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,568,625.0</u>	<u>7,670,773.5</u>	102,148.5
Дансны өглөг	1,394.2	3,426.7	2,032.5
Засгийн газрын хувь оролцоо	7,567,230.8	7,667,346.8	100,116.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,568,625.0</u>	<u>7,670,773.5</u>	102,148.5

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийн өсөлт нь ШШГЕГ-ын даргын 2021 оны А/11 дугаар тушаалаар ахмадын сан байгуулах шийдвэр гарч, тус санд төвлөрүүлсэн орлогоос шалтгаалан 4,867.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын дансны эхний үлдэгдлээс авлага 25,545.8 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын байгууллагаас санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдлийн 79,842.3 мянган төгрөгийн өсөлт нь тайлант оны бараа, эмийн худалдан авалт нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн 576 дугаар тогтоолоор акталсан хөрөнгийн дүн болон элэгдэл, хорогдлын зардлаас шалтгаалан 8,107.1 мянган төгрөгөөр буурчээ.

Дансны өглөгт ЭМД-ын сангийн санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс 2,032.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,690,947.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,692,447.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 342,714.0 мянган төгрөгөөр бууруулж, 2,348,233.8 мянган төгрөгөөр баталсан байна

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг зориулж улсын төсвөөс 1,452,663.5 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 883,316.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр, туслах үйл ажиллагааны орлого 12,253.7 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,447,329.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 883,378.1 мянган төгрөг санхүүжилт олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 12,384.9 мянган төгрөг бүрдүүлжээ.

Урсгал зардлын гүйцэтгэл 2,342,143.9 мянган төгрөг буюу 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвөөс зарцуулагдаагүй 5,333.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70705	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	2,340,292.5	2,335,175.2	5,256.7	99.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,268,215.9	2,263,045.3	5,170.6	99.8
1.2	80102	Туслах үйл ажиллагааны зардал	12,253.7	12,323.4	69.7	96.1
1.3	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	45,894.5	45,894.5	-	100.0
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11,896.0	11,896.0	-	100.0
1.5	80821	Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2,032.4	2,016.0	16.4	99.1
2	70711	Шүүгч,гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах хөтөлбөр	7,941.3	7,941.3	-	100.0
2.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,941.3	7,941.3	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтээр 232,521.3 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээллээс 212,557.2 мянган төгрөгийн мэдээлэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын төсвийг хуваарилахдаа дээд шатны захирагч нь зориулалт нь өөрчлөгдсөн, тухайн байгууллага ашигладаггүй газрын төлбөрийг төсөвт тусгаж, зарцуулж байгаа асуудал болон төр эзэмшиж байгаа газрын эзэмшил, ашиглалтын асуудлыг хуулийн дагуу тухай бүрд нь шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2021 оны III улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 113,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 101,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулан 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 12,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул илрүүлэлтэд нэмж тусгалаа.

Хан-Уул дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 10000 м² /1 га/ газрыг конторын зориулалтаар эзэмшүүлэхээр олгосон боловч эмнэлгийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа тул зориулалтыг өөрчлүүлэх зөвлөмжийг завсрын аудитаар хэрэгжүүлсэн.

Өмнөх оны аудитаар 1 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн. Үүнээс 1 албан шаардлагын биелэлт 90.0 хувь, 22,518.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй, 2,849.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1				1		90.0
Зөвлөмж	5	25,368.1	3	22,518.5	2	2,849.6	75.0
Нийт дүн	6	25368.1	3	22,518.5	3	2,849.6	

3.11 Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал

Тус байгууллагын ашиглах зориулалттай, санхүүгийн тайланд 1,714,000.0 мянган төгрөгийн бүртгэлтэй Хан уул дүүргийн 11-р хороо Зайсангийн аман дахь 5.3 га газраас ашиглагч байгууллагад шилжүүлж шийдвэрлэснийг дараагийн аудитаар үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,540.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 26,540.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн. Байгууллагын дансанд бүртгэлтэй 3.7 га газрын эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх албан шаардлагаар хязгаарлалтай дүгнэлт өглөө.

4.2.1 Албан шаардлага

Тус байгууллагын ашиглах зориулалттай, санхүүгийн тайланд бүртгэлтэй Хан уул дүүргийн 11-р хороо Зайсангийн аман дахь 3.7 га газарт ШШГЕГ-ын харьяа байгууллагуудын албан хаагчдыг орон сууцаар хангах 828 айлын 10 блок орон сууц, үйлчилгээний төв бүхий төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь тухайн байгууллагын газар оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дансанд бүртгэлтэй 3.7 га газрын эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлээ.

4.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын ашиглах зориулалттай газрын 1.6 га газрыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны 4 дүгээр сарын 08-ны 0211828 дугаар шийдвэрээр газар ашиглах гэрчилгээг Боловсрол, шинжлэх ухааны яаманд шилжүүлсэн боловч, уг газрыг данс бүртгэлээс хасаагүй байна. ТӨБЗГ-ын 2019 оны 271 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-т хүсэлт хүргүүлж, шийдвэрийн дагуу газрыг ашиглах байгууллагад шилжүүлж, данс бүртгэлээс хасах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ШШГЕГ-ын 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны төсөвт 51,500.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн төсөв батлагдаж, өөрсдийн үйл ажиллагаанд ашиглахгүй байгаа газрын төлбөрийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Газрын төлбөрийг газар ашиглагч хуулийн этгээдийн төсөвт тусгуулах саналаа дээд шатны захирагчид хүргүүлж шийдвэрлэх

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа 20,944.6 мянган төгрөгийн НӨАТ-ын цахим баримтын бүрдлийг хангаагүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас цахим и-баримтыг татварын сайтад шивүүлэх хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим баримтыг тухай бүр бүрдүүлэх, татварын и-баримт цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгч и-баримтыг шивсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэх.

4.Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эмнэлгийн ажилтны буухиа тэмцээний арга хэмжээнд 3,600.0 мянган төгрөг, ШШГЕГ-ын 100 жилийн ойн арга хэмжээнд 1,996.1 мянган төгрөг нийт 5,596.1 мянган төгрөг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; заалтыг хэрэгжүүлэн ажиллах" гэсэн заалтуудтай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тэмцээн уралдаан, байгууллагын ойн арга хэмжээ зохион байгуулахгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулж байгаа асуудлыг таслан зогсоох, хэмнэлттэй зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр, аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	ШШЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг АХГ-2022/341/НА-СТА-ТШЗ	Тус байгууллагын ашиглах зориулалттай, санхүүгийн тайланд бүртгэлтэй Хан уул дүүргийн 11-р хороо Зайсангийн аман дахь 3.7 га газарт ШШГЕГ-ын харьяа байгууллагуудын албан хаагчдыг орон сууцаар хангах 828 айлын 10 блок орон сууцны барилгын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.	Байгууллагын дансанд бүртгэлтэй 3.7 га газрын эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх	1											
2		ШШГЕГ-ын 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны төсөвт 51,500.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн төсөв батлагдаж, өөрсдийн үйл ажиллагаанд ашиглахгүй байгаа газрын төлбөрийг төлсөн байна.	Төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж батлуулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх	1									1		
3		Тус байгууллагын ашиглах зориулалттай газрын 1.6 га газрыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны 4 дүгээр сарын 08-ны 0211828 дугаар шийдвэрээр газар ашиглах гэрчилгээг Боловсрол, шинжлэх ухааны яаманд шилжүүлсэн боловч, уг газрыг данс бүртгэлээс хасаагүй байна.	Холбогдох газарт хүсэлт хүргүүлж, шийдвэрийн дагуу газрыг ашиглах байгууллагад шилжүүлж, данс бүртгэлээс хасах	1										1	
4		Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа НӨАТ-ын цахим баримтын бүрдлийг хангаагүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас цахим и-баримтыг татварын сайтад шивүүлэх хяналт хэрэгжүүлээгүй байна.	Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим баримтыг тухай бүр бүрдүүлэх, татварын и-баримт цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгч и-баримтыг шивсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэх.	1	20,944.6									1	20,944.6

**ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5		Эмнэлгийн ажилтны буухиа тэмцээний арга хэмжээнд 3,600.0 мянган төгрөг, ШШГЕГ-ын 100 жилийн ойн арга хэмжээнд 1,996.1 мянган төгрөг нийт 5,596.1 мянган төгрөг зарцуулсан.	Төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж батлуулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх	1	5,596.1									1	5,596.1
Дүн				5	26,540.7									4	26,540.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг АХГ-2022/341/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээллээс 212,557.2 мянган төгрөгийн мэдээлэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл нийт 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх	1	212,557.2									1	212,557.2
Дүн				1	212,557.2									1	212,557.2
Нийт дүн				6	239,097.9									5	239,097.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 45/АДИСООС5

Улаанбаатар хот

АХГ- 2022/341/СТА-ПЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу гүйцэтгэсэн ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын ашиглах зориулалттай, санхүүгийн тайланд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд байршилтай Зайсангийн аман дахь 3.7 га газарт ШШГЕГ-ын харьяа байгууллагуудын албан хаагчдыг орон сууцаар хангах 828 айлын 10 блок орон сууц, үйлчилгээний төв барих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь тухайн байгууллагын газар оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1 "Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 онд А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд байршилтай Зайсангийн аман дахь 3.7 га газрын зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт хрүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Одсэр, ахлах нягтлан бодогч Б.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦӨТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-29 Docx

001080204